



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2024.04.19 № 453
танай _____ -ы № _____ -т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн
нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитын
тайланг хүргүүлж байна.

Хавсралт 30 хуудас

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ж.ТАНБААТАР

232430759



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2024/01/НА-СТА-ТЕЗ

Чингис хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: Oyuntuyad@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Энх-Амгалан Утас: 91119424 Аудитор: Б.Ариунаа Утас: 93032714 Аудитор: Н.Туяа Утас: 99799709 Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.4.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	11
3.4.2 Авлага.....	12
3.4.3 Урьдчилгаа.....	14
3.4.5 Бараа материал.....	15
3.4.6 Нөөцийн бараа.....	16
3.4.7 Үндсэн хөрөнгө.....	16
3.4.8 Өр төлбөр.....	18
3.4.9 Засгийн газрын хувь оролцоо.....	19
4. Аудитын тайлан.....	20
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.4 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	22
5. Аудитын илрүүлэлт.....	23
5.1 Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	23
5.2 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт.....	25
5.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга:.....	25
5.2.2 Төсвийг ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн зөвлөмж:.....	25
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖДБДС	Жижиг дунд бизнесийг дэмжих сан
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НА	Нотлох аудит
НХХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024.04.19 № 458
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Ц.ЧОГСОМЖАВ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Хэнтий аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хэнтий аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 27,457.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 8,733.5 сая төгрөгийн авлага, 485.9 сая төгрөгийн урьдчилгаа, 17,062.2 сая төгрөгийн бараа материал, 171,946.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 226,020.1 сая төгрөг байна.

Тайлант онд улсын төсвөөс 25,201.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 12,166.2 сая төгрөгийн орлогын шилжүүлэг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,950.9 сая төгрөг, улсын төсвөөс хөрөнгө оруулалтын санхүүжилт 83,332.6 сая төгрөг авч, татвар болон татварын бус орлогоор 94,201.1 сая төгрөгийг бүрдүүлж, орон нутгийн төсвийн байгууллага ерөнхий орлогын дансанд 3,944.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Аймгаас сумдад олгох дэмжлэгт 12,626.1 сая төгрөг, төсвийн байгууллагуудад 63,453.7 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

232420550

Нэмэлт санхүүжилтийн дансанд 4,200.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 3,928.1 сая төгрөгийг зарцуулан үлдэгдэл 272.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 38,332.0 сая төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрч, 7,349.6 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 30,982.4 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлээ.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, тайлагнах талаар заавар, чиглэл өгч ажиллахгүй байгаагаас Төрийн аудитын газарт шаардлага хангахгүй тайлан ирүүлж аудитыг гүйцэтгэхэд хүндрэл учруулж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		70,902,538.70	54,073,843.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	21,150,604.50	27,457,760.20
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	6,588,901.70	8,733,547.00
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	855,320.30	485,918.10
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	39,934,522.00	17,062,194.80
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	98,877.80	132,423.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	2,274,312.50	202,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		133,679,852.10	171,946,296.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	133,679,852.10	171,946,296.00
39200	Биет хөрөнгө		122,484,889.80	156,900,224.60
39300	Биет бус хөрөнгө	13	11,194,962.30	15,046,071.30
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		204,582,390.90	226,020,139.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		30,042,714.80	35,932,051.20
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	17,858,399.70	23,152,948.90
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	13,976.20	293,333.00
41300	Өглөг	17а, 17б	5,673,068.60	14,519,727.00
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	12,171,354.90	8,339,888.80
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		12,184,315.00	12,779,102.30
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	12,184,315.00	12,779,102.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		174,539,676.10	190,088,087.90
51	Засгийн газрын хувь оролцоо		174,539,676.10	190,088,087.90
51100	Засгийн газрын оруулсан капитал		30,797,848.50	32,546,178.30
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		2,775,386.20	2,006,893.50
51200	Хуримтлагдсан үр дүн		125,452,298.60	140,128,520.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		15,514,142.80	15,406,495.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		204,582,390.90	226,020,139.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		143,011,598.60	206,565,912.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО		28,867,274.80	28,822,879.70
110	Орлогын албан татвар		19,123,578.80	19,601,223.90
1100	Хувь хүний орлогын албан татвар		13,074,519.40	17,758,787.60
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-638,940.60	-752,089.60
1103	ААН-ын орлогын албан татвар		6,688,000.00	2,594,525.80
113	Хөрөнгийн албан татвар		2,612,309.80	2,687,633.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж		7,131,386.20	6,534,022.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	60,483,143.10	88,900,133.00
120	Нийтлэг татварын бус орлого		40,324,540.60	51,230,967.30
121	Хөрөнгийн орлого		436,878.10	301,270.10
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		19,721,724.40	37,367,895.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		53,661,180.70	88,842,900.10
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	53,717,640.40	61,149,058.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ		53,715,852.80	61,100,522.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		51,838,907.30	60,032,708.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		10,430,892.80	14,194,284.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,279,487.20	1,783,179.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		9,467,372.10	2,194,275.20
2104	Хангамж, бараа материалын зардал		1,349,153.90	1,705,261.20
2105	Нормативт зардал		262,198.80	783,449.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,195,245.70	814,545.60
2107	Томилолт, зочны зардал		264,545.80	538,248.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		7,780,514.50	20,445,950.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		19,809,496.50	17,573,514.10
212	ТАТААС		8,061.50	329,839.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,868,884.10	737,974.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,787.50	48,536.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		89,293,958.30	145,416,854.10
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		42,064.80	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		179,240,142.10	131,687,706.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-89,904,119.00	13,729,147.40

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,501,398.70	0	259,501,398.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,173,813.80	0	6,173,813.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,675,212.40	0	265,675,212.40
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-15,586.80	0	-15,586.80
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	73,911.30	0	73,911.30
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	-1,289,741.90	0	-1,289,741.90
8	Зарласан ногдол ашиг	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	-89,904,119.00	0	-89,904,119.00
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	174,539,676.10	0	174,539,676.10
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	174,539,676.10	0	174,539,676.10
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	211,567.20	0	211,567.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	174,751,243.30	0	174,751,243.30
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-107,647.10	0	-107,647.10
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,478,709.80	0	2,478,709.80
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	-763,365.50	0	-763,365.50
18	Зарласан ногдол ашиг	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	13,729,147.40	0	13,729,147.40
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	190,088,087.90	0	190,088,087.90

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		120,810,477.20	183,313,139.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО		28,867,274.80	29,955,155.20
110	Орлогын албан татвар		19,123,578.80	20,733,499.40
1100	Хувь хүний орлогын албан татвар		13,074,519.40	20,893,673.40
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-638,940.60	-752,089.60
1103	ААН-ын орлогын албан татвар		6,688,000.00	591,915.50
113	Хөрөнгийн албан татвар		2,612,309.80	2,687,633.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж		7,131,386.20	6,534,022.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		917,396.80	1,204,508.50
1181	Газрын төлбөр		2,125,840.10	1,857,882.90
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		4,088,149.40	3,471,631.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		37,814,526.40	64,245,977.80
120	Нийтлэг татварын бус орлого		17,655,923.80	26,576,812.10
121	Хөрөнгийн орлого		436,878.10	301,270.10
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		19,721,724.40	37,367,895.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		54,128,676.00	89,112,006.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		50,875,991.40	65,394,856.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ		50,875,991.40	65,394,856.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		47,600,533.70	64,300,682.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		12,234,264.20	16,101,487.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,937,892.00	2,377,439.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		10,528,498.20	2,578,535.50
2104	Хангамж, бараа материалын зардал		4,033,206.80	6,274,299.40
2105	Нормативт зардал		254,266.80	748,750.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,341,239.90	955,094.50
2107	Томилолт, зочны зардал		266,508.80	552,047.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		7,196,408.70	20,810,090.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		9,808,248.40	13,902,937.50
211	ХҮҮ		344,361.00	0
212	ТАТААС		7,094.50	341,339.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,924,002.20	752,834.10

**Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		69,934,485.80	117,918,282.60
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		0	549.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		68,969,039.90	109,671,648.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		68,969,039.90	109,671,648.40
2200	Дотоод эх үүсвэрээр		68,969,039.90	109,671,648.40
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-68,969,039.90	-109,671,098.90
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-1,856,325.30	-1,940,028.00
14	Бусад эх үүсвэр		0	320,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		1,809,491.90	2,232,721.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		46,833.30	27,307.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		-890,879.30	6,307,155.70
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		22,041,483.80	21,150,604.50
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		21,150,604.50	27,457,760.20

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар “Аймгийн эдийн засгийн тогтвортой өсөлт болон нийгмийн үйл ажиллагааг бүхий л салбарын хүрээнд хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажил үйлчилгээг хууль эрх зүйн бүрэн хяналтад, үр ашигтайгаар хуваарилан зарцуулахад хяналт тавин удирдан ажиллахад оршино” гэж зорилгоо тодорхойлон ажилласан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан аймгийн Засаг даргын бүрэн эрхийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

60.1.Аймгийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

60.1.1.хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;

60.1.2.аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;

60.1.3.аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

60.1.4.аймгийн төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

60.1.5.аймгийн ТЕЗ-ийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;

60.1.6.аймгийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, аймгийн өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэрэг асуудлаар захиран зарцуулах санал боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан шийдвэрлүүлэх;

60.1.21.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулаагүй байна.

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь эрсдэлийн ангилалд үндэслэн 2023 онд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны 1 байгууллагад, санхүүгийн хяналтыг, дотоод аудитыг 6 байгууллагад хийжээ.

Хяналт шалгалтаар Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон салбарын хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 28.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчил арилгуулах албан шаардлага өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хэнтий аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ Монгол улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ✓ Хэнтий аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолоор “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” тогтоол;
- ✓ Хэнтий аймгийн ИТХ-ын 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 18 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” тогтоол;
- ✓ Хэнтий аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 20 дугаар хуралдааны 07 дугаар тогтоолоор “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолуудад өөрчлөлт орсон байна.

3.4.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 21,150.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 27,457.8 сая төгрөг болж 6,307.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	15.8	3.0	(12.8)
Төгрөг	15.8	3.0	(12.8)
Нэмэлт санхүүжилт	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	20,814.1	26,804.4	5,990.3
Замд яваа мөнгөн хөрөнгө	320.7	650.4	329.7
Хадгаламж			-
Дүн	21,150.6	27,457.8	6,307.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	5,464.4	4,642.0	(822.4)
Төсөл/ сан	222.6	211.4	(11.2)
Төрийн сан	14,965.7	21,891.4	6,925.7
ТӨҮГ болон ОНӨҮГ	497.9	713.0	215.1
Дүн	21,150.6	27,457.8	6,307.2

Эх сурвалж: Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Касст байгаа бэлэн мөнгөний үлдэгдэлд Хэнтий-Ус ХХК-ийн 3.0 сая төгрөг байна. Банканд байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Төрийн сангийн харилцах дансны 25,868.9 сая төгрөг, арилжааны банкны харилцах дансны 710.9 сая төгрөг, нийт 26,804.4 сая төгрөг байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн 650.4 сая төгрөгийн үлдэгдлээс 3.2 сая төгрөг нь аймгийн татварын орлого, 647.2 сая төгрөг нь сумдын татварын орлого байна.

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг байгууллагын төрлөөр нь авч үзвэл төсөвт байгууллага 4,642.0 сая төгрөг буюу 16.9 хувийг, төрийн сан 21,891.4 сая төгрөг буюу 79.7 хувийг, ОНӨААТҮГ 713.0 сая төгрөг буюу 2.6 хувийг, төсөл сан 211.4 сая төгрөг буюу 0.8 хувийг тус тус эзэлж байна.

Төрийн сангийн үлдэгдлийн 13,098.9 сая төгрөг нь аймгийн төрийн сангийн үлдэгдэл, 8,142.1 сая төгрөг нь сумын төрийн сангийн үлдэгдэл, 2,105.9 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл, 2,052.0 сая төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл, 50.4 сая төгрөг нь Байгаль хамгаалах сангийн үлдэгдэл, 161.0 сая төгрөг нь Эрсдэлээс хамгаалах сангийн үлдэгдэл, 258.6 сая төгрөг нь Замын сан, 211.4 сая төгрөг нь Захиалагчийн хяналт дансны үлдэгдэл байна.

Аймгийн төрийн сан дахь үлдэгдэл 13,098.9 сая төгрөгийг авч үзвэл Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл 12,003.1 сая төгрөг буюу 91.6 хувийг, нэмэлт дансны үлдэгдэл 272.2 сая төгрөг буюу 2.1 хувийг, аймгийн ерөнхий орлогын данс 823.6 сая төгрөг буюу 6.3 хувийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой нийт 48.9 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн. Үүнээс 6.4 сая төгрөгийн 7 алдааг санхүүгийн тайланд залруулсан байна. (Залруулаагүй зөрчлийг зөрчлийн утга, сум, байгууллагаар нь дурдвал)

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 7.7 сая төгрөгийн 3 зөрчил илэрсэнд 2.6 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 5.1 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- Орон нутгийн өмчийн газар 1.6 сая төгрөг
- Аймгийн ИТХ 1.0 сая төгрөг
- Жаргалтхаан сумын ИТХ 5.1 сая төгрөг

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 27.8 сая төгрөгийн 1 зөрчил илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлээ.:

- Дадал сумын ЗДТГ 27.8 сая төгрөг

Дотоод хяналт болон хариуцлагатай холбоотой 7.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлсэн.

- Өмнөдэлгэр сумын ЗДТГ 7.0 сая төгрөг

3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 6,588.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,733.5 сая төгрөг болж, 2,144.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.3	2.1	(0.2)

**Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Төлбөртэй үйлчилгээний авлага	122.1	127.8	5.7
Татаас, санхүүжилтийн авлага			-
Зээлийн хүүгийн авлага	16.8	36.1	19.3
Дансны авлага /ТӨҮГ/	207.6	219.7	12.1
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	43.3	43.1	(0.2)
Бусад авлага	750.2	2,410.4	1,660.2
Зээлийн авлага	5,446.6	5,894.3	447.7
Дүн	6,588.9	8,733.5	2,144.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			-
Төсөвт байгууллага	5,807.4	6,410.1	602.7
Төсөл/ сан	274.6	274.6	-
Төрийн сан	30.0	30.0	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	476.9	2,018.8	1,541.9
Дүн	6,588.9	8,733.5	2,144.6

Эх сурвалж: Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын нэмэлт дансны авлага 237.3 сая төгрөгийг төрийн санд төвлөрүүлж, устгах бичилтийг бүрэн хийсэн байна.

Нийт авлагын 73.4 хувийг төсөвт байгууллага, 3.1 хувийг төсөл сан, 0.3 хувийг Төрийн сан, 23.1 хувийг ОНӨААТҮГ-ын үлдэгдэл эзэлж байна.

Төсөвт байгууллагын авлага:

Төсөвт байгууллагын авлагын үлдэгдлийн 88.2 хувь буюу 5,864.3 сая төгрөг нь тусгай сангуудын зээлийн авлага байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн 21 сум, тосгоны 1133 зээлдэгчид олгосон 5,864.3 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна. Авлагыг насжилтаар ангилбал хугацаандаа буюу 1-3 жилийн насжилттай 189 зээлийн 2,025.1 сая төгрөгийн, 4-5 жилийн насжилттай 115 зээлийн 571.5 сая төгрөгийн, 5-аас дээш жилийн насжилттай 829 зээлийн 3,267.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт зээлийн 29.2 хувь буюу 1,724.5 сая төгрөгийн 306 зээлийг шүүхэд шилжүүлснээс 1,293.9 сая төгрөгийн 240 зээлд шүүхийн шийдвэр гарсан байна. Хугацаа хэтэрсэн 2,491.4 сая төгрөгийн 670 зээлийн үлдэгдлийг шүүхэд шилжүүлээгүй байна.

Өмнөх оны үлдэгдлээс 447.7 сая төгрөгөөр өсөж авлагын үлдэгдэл 5,864.3 сая төгрөг болсон нь тайлант онд Бор-Өндөр, Хэрлэн, Батноров, Биндэр, Норовлин, Өмнөдэлгэр, Жаргалтхаан, Мөрөн сумд зээл олгосноос авлагын үлдэгдэл 15.4-245.6 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Батширээт, Баян-Овоо, Баян-Адарга, Баянмөнх, Баянхутаг, Галшар, Дадал, Дархан, Дэлгэрхаан, Цэнхэрмандал сум, Гурванбаян,Өлзийт, Хэрлэнбаян-Улаан, Бэрх тосгоны хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдлийг 0.2-71.6 сая төгрөгөөр барагдуулж ажилласан байна.

Төлбөртэй үйлчилгээний авлагын үлдэгдлийн 87.1 хувь буюу 111.3 сая төгрөг нь Бор-Өндөр тохижилтын, 12.9 хувь буюу 16.6 сая төгрөг нь Цэгцүүлэн дом өрхийн эмнэлгийн авлага байна.

Төсөл, сан, төрийн сангийн авлага:

Төсөл, сангийн авлагын үлдэгдэлд Орон сууцны сангийн 274.6 сая төгрөг, төрийн сангийн 30.0 сая төгрөг байна. Он удаан жил болсон авлагыг барагдуулах талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

ОНӨААТҮГ-ын авлага:

ОНӨААТҮГ-ын нийт авлагын үлдэгдлийн 78.6 хувийг Хэнтий орон сууц ОНӨААТҮГ-ын 1,586.8 сая төгрөг, 3 хувийг Хэнтий-Ус ХХК-ийн 266.0 сая төгрөгийн авлага эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагын данстай холбоотой нийт 247.9 сая төгрөгийн 24 алдаа, зөрчил илэрснийг 82.0 сая төгрөгийн 19 алдааг санхүүгийн тайланд залруулж, 94.3 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 71.6 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн. (илэрсэн алдаа, зөрчлийг томоохон дүнтэй сум, байгууллагаар нь дурдвал)

- Хэрлэн сумын хоршоо хөгжүүлэх сан 78.8 сая төгрөг
- Дархан хот тохижилт 71.6 сая төгрөг
- Дадал сумын ОНХС 10.0 сая төгрөг
- Дархан сумын ЗДТГ 5.4 сая төгрөг

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 855.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 485.9 сая төгрөг болж 369.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/ сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	764.1	423.4	(340.7)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.1		(0.1)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	90.3	61.3	(29.0)
Цалингийн урьдчилгаа	0.8	1.2	0.4
Томилолтын урьдчилгаа			-
Дүн	855.3	485.9	(369.4)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			-
Төсөвт байгууллага	718.4	483.1	(235.3)
Төсөл/ сан			-
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	136.9	2.8	(134.1)
Дүн	855.3	485.9	(369.4)

Эх сурвалж: Хэнтий аймгийн ТЭЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан нийт зардлын 99.4 хувийг төсөвт байгууллага, ОНХСан, 0.6 хувийг ОНӨААТҮГ-ын үлдэгдэл эзэлж байна.

Төсөвт байгууллагын урьдчилгаа дансны 483.1 сая төгрөгийн үлдэгдлийн 62.6 хувь буюу 302.6 сая төгрөг нь сумдын ОНХС-ийн дуусаагүй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Урьдчилж гарсан зардал данстай холбоотой дансны бичилт буруу хийсэн, бүртгэлд тусгаагүй нийт 381.6 сая төгрөгийн 10 алдаа илрүүлж алдааг санхүүгийн тайланд залруулав.

- Норовлин сумын ОНХС 168.9 сая төгрөг
- Батширээт сумын ЗДТГ 62.6 сая төгрөг
- Дадал сумын ОНХС 82.7 сая төгрөг

- Цэнхэрмандал сумын ОНХС 22.5 сая төгрөг
- Дархан сумын ОНХС 20.0 сая төгрөг
- Бор-Өндөр сумын ЗДТГ 14.0 сая төгрөг
- Дэлгэрхаан сумын ЗДТГ 8.0 сая төгрөгийг тус тус залруулсан байна.

3.4.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт данс үлдэгдэлгүй байна.

3.4.5 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 39,934.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 17,062.2 сая төгрөг болж 22,872.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа материал			
Тусгай зориулалтын материал	113.9	138.2	24.3
Эм боох материал	134.6	70.3	(64.3)
Дуусаагүй үйлдвэрлэл	-	-	-
Бэлэн бүтээгдэхүүн	3.4	1.6	(1.8)
Бичиг хэргийн материал	96.2	111.8	15.6
Аж ахуйн материал	2,339.7	2,318.1	(21.6)
Сэлбэг хэрэгсэл	134.6	121.2	(13.4)
Түлш, шатах тослох материал	89.0	139.2	50.2
Барилгын засварын материал	99.1	51.6	(47.5)
Хүнсний материал	0.1	0.9	0.8
Бусад хангамжийн материал	36,366.0	13,480.5	(22,885.5)
Биологийн хөрөнгө		13.0	13.0
Мал амьтад	557.9	615.8	57.9
Дүн	39,934.5	17,062.2	(22,872.3)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>	-	-	-
Төсөвт байгууллага	38,984.4	16,265.5	(22,718.9)
Төсөл/ сан			-
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	950.1	796.7	(153.4)
Дүн	39,934.5	17,062.2	(22,872.3)

Эх сурвалж: Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын үлдэгдлийн 95.3 хувь нь төсөвт байгууллагад, 4.7 хувь нь ОНӨААТҮГ-ын үлдэгдэл байна.

Бараа материал дансны үлдэгдлийн 79 хувийг бусад хангамжийн материалын үлдэгдэл эзэлж байна.

Бусад хангамжийн материал дансанд он дамжин хийгдэж байгаа улсын төсвийн хөрөнгө оруулалтын 12,083.1 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтын 100.0 сая төгрөг, аймгийн ОНХС-ийн 439.5 сая төгрөгийн дуусаагүй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг тус тус бүртгэсэн байна. /Хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралт 1-р хавсаргав/

Аудитын илрүүлэлт:

Бараа материалын данстай холбоотой нийт 140.4 сая төгрөгийн 9 алдаа, зөрчил илрүүлж, 14.3 сая төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулсан. (Залруулаагүй зөрчлийг дурдвал)

1. Бараа материалд тавих хяналт сул, тогтоосон норм хэтрүүлэн зарцуулсан 1.4 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:
 - Өмнөдэлгэр сумын тохижилт үйлчилгээ 1.0 сая төгрөг
 - Биндэр сумын ЗДТГ 0.4 сая төгрөг

2. Бараа материалын үлдэгдлийг бүртгэл тайланд зөрүүтэй илэрхийлсэн 17.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:
 - Өмнөдэлгэр сумын ОНХС 13.3 сая төгрөг
 - Бор-Өндөр сумын ИТХ 4.2 сая төгрөг

3. Бараа материалыг тоолоогүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй 107.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:
 - Галшар сумын ЗДТГ 107.2 сая төгрөг

3.4.6 Нөөцийн бараа

Нөөцийн бараа материалын дансны эхний үлдэгдэл 98.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 132.4 сая төгрөг болж, 33.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Нөөцийн барааны үлдэгдэл

/ сая төгрөг /

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Нөөцийн бараа	-	-	
Барааны нөөц			
Тэжээлийн нөөц	98.9	132.4	33.5
Бусад нөөц			-
Дүн	98.9	132.4	33.5
Үүнээс, байгууллагын төрлөөр	-	-	-
Төсөвт байгууллага	98.9	132.4	33.5
Төсөл/ сан			-
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	-	-	-
Дүн	98.9	132.4	33.5

Нөөцийн барааны үлдэгдэл 132.4 сая төгрөг нь сумдын өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор бэлтгэсэн малын өвс тэжээл байна. Сумдаар нь авч үзвэл Баян-Адарга сум 12.2 сая төгрөг, Баянмөнх сум 10.5 сая төгрөг, Баянхутаг сум 16.8 сая төгрөг, Батширээт сум 10.7 сая төгрөг, Бэрх тосгон 7.7 сая төгрөг, Галшар сум 3.3 сая төгрөг, Жаргалтхаан сум 5.5 сая төгрөг, Мөрөн сум 15.4 сая төгрөг, Норовлин сум 31.3 сая төгрөг, Өмнөдэлгэр сум 19.0 сая төгрөгийн нөөцийн үлдэгдэлтэй байна.

3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 165,368.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 213,780.2 сая төгрөг болж, 48,411.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/ сая төгрөг /

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	154,109.0	198,652.3	44,543.3
Барилга, байгууламж, орон сууц	109,181.3	141,206.5	32,025.2
Авто тээврийн хэрэгсэл	8,617.5	11,090.1	2,472.6
Машин тоног төхөөрөмж	9,272.7	10,935.6	1,662.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,638.3	2,908.3	270.0
Зам, гүүрний байгууламж	17,062.3	23,777.6	6,715.3
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	17.0	16.9	(0.1)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	546.2	546.2	-
Бусад үндсэн хөрөнгө	6,761.7	8,159.1	1,397.4
Дуусаагүй барилга, байгууламж			-
Ном	12.0	12.0	-
Биет бус хөрөнгө	11,259.6	15,127.9	3,868.3
Программ хангамж	326.3	333.4	7.1
Бусад биет бус хөрөнгө	10,933.3	14,794.5	3,861.2
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + бусад	-	-	-
Дүн	165,368.6	213,780.2	48,411.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			-
Төсөвт байгууллага	126,524.9	173,592.6	47,067.7
Төсөл/ сан			-
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	38,843.7	40,187.6	1,343.9
Дүн	165,368.6	213,780.2	48,411.6

Эх сурвалж: Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 81.2 хувийг төсвийн байгууллага, 18.8 хувийг ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгүүд эзэлж байна.

Тайлант онд нийт 48,411.6 сая төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгө 1,458.9 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 4,445.2 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 4,030.3 сая төгрөг, бусад эх үүсвэрээс бий болсон 40,979.5 сая төгрөгийн хөрөнгийг орлого авсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөтэй холбоотой 14,033.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

- 13,987.3 сая төгрөгийн 48 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнээс томоохон дүнтэй сум, байгууллагыг дурдвал:
 - Өндөрхаан тохижилтын газар 5,922.8 сая төгрөг
 - Баян-Овоо сумын ЗДТГ 3,058.5 сая төгрөг
 - Дадал сумын ЗДТГ 2,768.5 сая төгрөг
 - Өмнөдэлгэр сумын ЗДТГ 358.3 сая төгрөг
 - Хэнтий орон сууц ОНӨҮГ 202.0 сая төгрөг
 - Цэнхэрмандал сумын ЗДТГ 170.6 сая төгрөг
- Залруулагдаагүй 46.0 сая төгрөгийн зөрчлийн 15.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 30.5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн. Үүнд:
 - Жаргалтхаан тохижилт үйлчилгээ 15.5 сая төгрөгийн 1 албан шаардлага
 - Хэрлэн сумын ОНХС 30.5 сая төгрөг 3 зөвлөмж

3.4.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 30,042.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 35,932.0 сая төгрөг болж 5,889.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ сая төгрөг /

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өссөн+ Буурсан -</u>
<u>Богино хугацаат өр төлбөр дүн</u>	17,858.4	23,152.9	5,294.5
<u>Төгрөг</u>	14.0	293.3	279.3
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	14.0	293.3	279.3
<u>Өглөг</u>	5,673.0	14,519.7	8,846.7
Ажилчидтай холбогдсон өглөг	7.8	1.8	(6.0)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2.6	0.0	(2.6)
<u>Бусад өглөг</u>	5,662.6	14,517.9	8,855.3
Байгууллагад төлөх өглөг	4,852.2	12,828.9	7,976.7
Хувь хүмүүст төлөх өглөг	109.0	198.2	89.2
Татварын өглөг /ТӨҮГ/	117.2	441.3	324.1
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	5.7	14.3	8.6
Дансны өглөг /ТӨҮГ/	578.5	1,035.2	456.7
<u>Урьдчилж орсон орлого</u>	12,171.4	8,339.9	(3,831.5)
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	7,646.9	7,164.6	(482.3)
Бусад урьдчилж орсон орлого	4,524.5	1,175.3	(3,349.2)
<u>Урт хугацаат өр төлбөр дүн</u>	12,184.3	12,779.1	594.8
<u>Урт хугацаат зээл</u>	12,184.3	12,779.1	594.8
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	12,184.3	12,779.1	594.8
<u>Нийт дүн</u>	30,042.7	35,932.0	5,889.3
<u>Үүнээс, байгууллагын төрлөөр</u>			-
Төсөвт байгууллага	46.9	40.2	(6.7)
Төсөл, сан			-
Төрийн сан	6,800.7	12,003.1	5,202.4
ТӨҮГ болон ОНӨҮГ	23,195.1	23,888.7	693.6
<u>ДҮН</u>	30,042.7	35,932.0	5,889.3

Эх сурвалж: Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 0.1 хувийг төсөвт байгууллага, 33.4 хувийг Төрийн сан, 66.5 хувийг төрийн болон орон нутгийн өмчит газруудын өр төлбөр эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөр үлдэгдэл 23,152.9 сая төгрөг болж 5,294.5 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Хэнтий ус ХХК 7,164.6 сая төгрөг, Дархан тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ 1,089.1 сая төгрөг, Цэнхэрмандал ойн анги 42.4 сая төгрөг, Өмнөдэлгэр ойн анги 42.1 сая төгрөг, Дэлгэрхаан аварга тохижилт 1.1 сая төгрөг, Хэнтий орон сууц ОНӨААТҮГ 0.5 сая төгрөгийн үлдэгдэл байна. Дээрх байгууллагуудын урьдчилж орсон орлогын үлдэгдэл нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон дулааны шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж болон бусад хөрөнгийг орон нутгийн өмчит газруудад шилжүүлсэнтэй холбоотойгоор үүссэн байна.
- Аймгийн төсвийн орлогод 2023 онд олгох ААНОАТ-ын 2,002.6 сая төгрөгийг 2022 онд урьдчилан авч өр үүсгэснийг тайлант онд орлогоор хүлээн зөвшөөрч өглөгийг барагдуулсан байна.

Урт хугацаат өр төлбөрт “Хэнтий-Ус” ХХК-ийн Азийн хөгжлийн банкнаас 2003 онд “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл” МОН-1907-ийн хүрээнд зүүн болон төвийн бүсийн аймгийн “Нийтийн аж ахуй үйлчилгээний байгууллагын ажил үйлчилгээний менежментийн чадавхыг дээшлүүлэх”-д зориулан авсан зээлийн үлдэгдэл 1,149.9 сая төгрөг, 2019 онд “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт”-ээр авсан зээлийн үлдэгдэл 11,629.2 сая төгрөг байна.

Тайлант онд урт хугацаат зээлийн төлбөрт 115.7 сая төгрөг, хүүгийн төлбөрт 610.6 сая төгрөг, нийт 725.7 сая төгрөгийг аймгийн төсвөөс төлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Өглөгтэй холбоотой 1,131.6 сая төгрөгийн 8 алдааг санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Хэнтий-Ус ХХК 1,123.0 сая төгрөг
- Баян-Адарга сумын ХХС 5.1 сая төгрөг
- Жаргалтхаан сумын ИТХ 2.0 сая төгрөг
- Дархан тохижилт 1.4 сая төгрөг

3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 174,539.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 190,088.1 сая төгрөг болж, 15,548.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №10 Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+, бууралт /-/</u>
<u>Засгийн газрын хувь оролцоо</u>	<u>33,573.2</u>	<u>34,553.1</u>	<u>979.9</u>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	30,797.8	32,546.2	1,748.4
Өмч /төрийн/ ТӨҮГ/	2,775.4	2,006.9	(768.5)
Өмч /Хувийн/ ТӨҮГ/			-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	<u>125,452.3</u>	<u>140,128.5</u>	<u>14,676.2</u>
Өмнөх үеийн үр дүн	215,356.4	126,399.3	(88,957.1)
Тайлант үеийн үр дүн	(89,904.1)	13,729.2	103,633.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,514.1	15,406.5	(107.6)
Дүн	174,539.6	190,088.1	15,548.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	150,768.2	166,196.9	15,428.7
Төсөл, сан	497.2	486.0	(11.2)
Төрийн сан	8,073.2	9,681.0	1,607.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	15,201.0	13,724.2	(1,476.8)
Дүн	174,539.6	190,088.1	15,548.5

Эх сурвалж: Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хөрөнгийн дахин үнэлгээ дансны үлдэгдэл 107.6 сая төгрөгөөр буурсан нь данснаас хассан хөрөнгийн дахин үнэлгээний дүн буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн тайланд орлого, зардалтай холбоотой 2,557.8 сая төгрөгийн 31 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Өндөр дүнтэй залруулгаас дурдвал:

- Хэнтий орон сууц ОНӨҮГ 699.8 сая төгрөг
- Хэнтий-Ус ХХК 610.6 сая төгрөг

- Батширээт ойн анги 545.1 сая төгрөг
- Өмнөдэлгэр сумын Засаг дарга 120.0 сая төгрөг
- Дархан тохижилт 86.0 сая төгрөг

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Энх-Амгалан, аудитор Н.Туяа, Б.Ариунаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 9/667 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 53,717.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 537.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 402.9 сая төгрөгөөр тогтоож аудитын явцад гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн ТЕЗ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн дүн дараах байдалтай байна. Үүнд:

Тендер шалгаруулсан худалдан авах ажиллагаанд 41,015.3 сая төгрөгийн 56 мэдээлэл байршуулахаас 9,844.0 сая төгрөгийн 26 мэдээллийг байршуулаагүй, төсөв, өмч хөрөнгө зарцуулах 2,812.7 сая төгрөгийн 183 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт:

Орон нутгийн өмчит 1 байгууллага 1,573.3 сая төгрөг, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2 байгууллага 2,151.5 мэдээллийг байршуулаагүй, зөрүүтэй мэдээлсэн зэрэг нийт 3,724.8 сая төгрөгийн 3 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах, мэдээллийг бүрэн, үнэн зөв байршуулж ажиллах 3 зөвлөмж өгсөн.

ТЕЗ-ийн хувьд тендер шалгаруулсан худалдан авах ажиллагааны 9,844.3 сая төгрөгийн 26 мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

Өгсөн зөвлөмж: *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хариуцсан мэдээллийг ил тод нээлттэй мэдээлэх*

4.4 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудитаар ТЕЗ-ийн харьяа байгууллагын тайланд нийт 18,647.0 сая төгрөгийн 138 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Залруулгыг төрлөөр авч үзвэл:

- Үндсэн хөрөнгө бүртгэлтэй холбоотой 13,987.3 сая төгрөгийн 48 алдаа
- Авлагын бүртгэлтэй холбоотой 82.0 сая төгрөгийн 19 алдаа
- Өглөгийн бүртгэлтэй холбоотой 1,131.6 сая төгрөгийн 8 алдаа
- Зардлын бүртгэлтэй холбоотой 1,156.2 сая төгрөгийн 21 алдаа
- Урьдчилгаа данстай холбоотой 381.6 сая төгрөгийн 10 алдаа
- Орлогын бүртгэлтэй холбоотой 1,733.4 сая төгрөгийн 18 алдаа
- Үр дүнгийн тайлантай холбоотой 154.2 сая төгрөгийн 3 алдаа
- Бараа материалын бүртгэлтэй холбоотой 14.3 сая төгрөгийн 4 алдаа
- Мөнгөн хөрөнгийн бүртгэлтэй 6.4 сая төгрөгийн 7 алдааг залруулсан байна.

Дээрх алдааны нийт дүн нь үр дүнгийн тайлангийн нийт орлогын 9 хувьтай тэнцэж байна. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрч буй алдаа нь дараах нөхцөл байдлаас шалтгаалсан байна. Үүнд:

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийн бүртгэлд Орон нутгийн өмчийн газраас тавих хяналт хангалтгүй, данс бүртгэлд бүрэн тусгадаггүй, төрийн байгууллагууд уялдаа холбоогүй ажиллаж байна.
- Нягтлан бодогчийг сургалтад хамруулах, дадлагажуулах ажил хангалтгүй, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллаагүй байна.
- Нягтлан бодогчид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд зааснаар ҮНЭН ЗӨВ БАЙХ зарчмыг баримтлахгүй байгаатай холбоотой байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид 15.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлснийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт №12 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилт ийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	3	15.0	3	15.0	-	-	100
Зөвлөмж	-	-	-	-	-	-	-
Нийт	3	15.0	3	15.0	-	-	100

4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. Аудитын илрүүлэлт

5.1 Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж гаргалаа.

ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн 256 байгууллагаас төсвийн шууд захирагч 94, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 21, ТТЗ 22, ТЕЗ 1, гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих 118 байгууллага нийт 256 байгууллагын санхүүгийн тайлан аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 82 байгууллагад аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 28 ТШЗ, 5 ОНӨААТҮГ, 22 ТТЗ, 1 ТЕЗ нийт 55 байгууллагад дүгнэлт хүргүүлээ. Үүнд: “Өөрчлөлтгүй” 49, “Хязгаарлалттай” 6 дүгнэлт өгсөн байна.

Хүснэгт № 11 Хязгаарлалттай дүгнэлт өгсөн байгууллагын жагсаалт

№	Шалгагдагч байгууллагын нэр	Төсөв захирагчийн ангилал	Дүгнэлт
1	Галшар сумын Засаг даргын Тамгын газар	ТШЗ	Хязгаарлалттай
2	Дадал сумын Засаг даргын тамгын газар	ТШЗ	Хязгаарлалттай
3	Дархан сумын Засаг даргын тамгын газар	ТШЗ	Хязгаарлалттай
4	Цэнхэрмандал сумын Засаг даргын тамгын газар	ТШЗ	Хязгаарлалттай
5	Жаргалтхаан сумын Засаг дарга	ТТЗ	Хязгаарлалттай
6	Гурванбаян тосгоны Захирагч	ТТЗ	Хязгаарлалттай

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн, / ТТЗ, ТШЗ, ОНӨААТҮГ/ аудитаар нийт 22,420.4 сая төгрөгийн 152 алдаа, зөрчил илэрч, 18,315.2 сая төгрөгийн 130 алдааг залруулж, 3.9 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 274.4 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага хүргүүлж, 3,826.9 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

Нийт илэрсэн зөрчлийг санхүүгийн тайлагналын болон нийцлийн асуудлаар ангилж харуулбал:

Санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа, зөрчил

Аудитаар санхүүгийн 18,695.6 сая төгрөгийн 149 алдаа, зөрчил илрүүлж 18,315.2 сая төгрөгийн 130 алдааг залруулж, 3.9 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 274.4 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага хүргүүлж, 102.1 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлсэн.

Нийцлийн асуудалтай холбоотой зөрчил

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад нийцлийн асуудалтай холбоотой 3,724.8 сая төгрөгийн зөрчил илэрч 3 зөвлөмж хүргүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 20 санхүүгийн нэгтгэсэн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт, 2 төвлөрүүлэн захирагчид “Өөрчлөлттэй” буюу хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 2,316.1 сая төгрөгийн 11 алдаа, зөрчил илэрснээс 164.6 сая төгрөгийн 9 алдааг санхүүгийн тайлангийн аудитын явцад залруулж, 2,151.5 сая төгрөгийн зөрчил 2 зөвлөмж хүргүүлсэн.

Төсвийн шүүд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар:

Харьяа төсвийн 94 байгууллагаас 66 байгууллагад аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 28 дүгнэлт өгснөөс 24 байгууллагад “Өөрчлөлтгүй” дүгнэлт, 4 байгууллагад “Өөрчлөлттэй” буюу Хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 14,486.2 сая төгрөгийн 113 алдаа, зөрчил илрүүлснээс 14,193.9 сая төгрөгийн 97 алдааг залруулж, 2.9 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 258.9 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага хүргүүлж, 30.5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

ОНӨААТҮГ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар:

Харьяа орон нутгийн өмчит 21 байгууллагыг аудитад хамруулснаас, 5 байгууллагад “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгч, 16 байгууллагыг аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар 5,618.1 сая төгрөгийн 28 алдаа, зөрчил илэрснээс 3,956.7 сая төгрөгийн 24 алдааг санхүүгийн тайланд залруулж, 1.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 15.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,644.9 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлээ.

5.2 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 38,331.9 сая төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрч 7,349.5 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 30,982.4 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлээ.

Нийт илэрсэн зөрчлийг санхүүгийн тайлагналын болон нийцлийн асуудлаар ангилж харуулбал:

Санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа, зөрчил

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой 7,349.5 сая төгрөгийн 5 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

Нийцлийн асуудалтай холбоотой зөрчил

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар нийцлийн асуудалтай холбоотой 30,982.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж 4 зөвлөмж хүргүүлсэн.

5.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга:

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 7,349.6 сая төгрөгийн 5 алдаа илэрч нэгтгэсэн тайланд залрууллаа. Үүнд:

- УТХО-аар жил дамжин хэрэгжүүлж тайлант онд ашиглалтад оруулан үндсэн хөрөнгөөр бүртгэсэн 5,327.0 сая төгрөгийн Дадал, Баян-Овоо сумдын ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийг бусад хангамжийн материал дансанд давхар бүртгэсэн.
- Өмнөх оны ААНОАТ-ын 2,002.6 сая төгрөгийн урьдчилж орсон орлогыг бууруулахдаа 1,982.4 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогод, 16.8 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансны өглөгт, 3.3 сая төгрөгийг нэмэлтийн өглөгт тус тус бүртгэж хаасан.
- Зөгийн үүр хөтөлбөрийн хүрээнд богино хугацааны сургалтын төлбөрт шилжүүлсэн 7.2 сая төгрөгийг авлага үүсгээгүй байна.
- Малын эрсдэлээс хамгаалах сангийн мөнгөн гүйлгээний тайланд 1.6 сая төгрөгөөр орлого бууруулж бүртгэсэн.
- Малыг эрсдэлээс хамгаалах сангийн орлогыг үр дүнгийн тайланд орлогыг 11.2 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн алдааг тус тус залруулсан.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 30,982.4 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 4 зөвлөмж хүргүүлээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийцлийн асуудалтай холбоотой 9,844.0 сая төгрөгийн 26 мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй зөрчилд 1 зөвлөмж хүргүүлснийг тайлангийн 4.3.1-т илрүүлэлт хэсэгт дурдсан болно.

5.2.2 Төсвийг ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн зөвлөмж:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн 2,491.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн 670 зээлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, шүүхэд шилжүүлээгүй, зээлийн сангийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд бүртгүүлээгүй байгаа нь холбогдох хууль, тогтоомжтой нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын дагуу хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлэх, зээлийг гэрээнд заасан хугацааны дотор эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд чанаргүй активын ангилалд оруулж, Монгол банкны зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлдэгчийн ангилалд бүртгэх, хугацаа хэтэрсэн зээлийг Шүүх байгууллагад шилжүүлэн хамтран ажиллах.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 138 байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 61 байгууллагад 18,315.2 сая төгрөгийн 130 алдаа илэрч 44.2 хувь нь санхүүгийн тайлангаа алдаатай ирүүлснийг аудитын явцад залруулсан байна. Энэ нь төсөв захирагч, нягтлан бодогч нарын хариуцлагагүй байдал, нэгдсэн удирдлага, чиглэлээр хангаж ажиллаагүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж: Төсөв захирагчид санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг хангаж ажиллах, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг мөрдөж ажиллах, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн эрх бүхий албан тушаалтнууд төсөв захирагч, нягтлан бодогчдод санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотой үүрэг, чиглэл хүргүүлж нэгдсэн удирдлага арга зүйгээр хангаж ажиллах шаардлагатай байна.

3. Төсвийн ерөнхийлөн захирагч нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байдлаар боловсруулан батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус аймаг дахь Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн	5	7,349.5			5	7,349.5	5	7,349.5				
Дүн	5	7,349.5			5	7,349.5	5	7,349.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Худалдан авах ажиллагааны мэдээлэл байршуулаагүй	1	9,844.0						1	9,844.0
Дүн	1	9,844.0						1	9,844.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
НББ-ийн бодлогын баримт бичиггүй	1	-						1	-
ХХС-ийн зээлийн авлага барагдуулж ажиллаагүй	1	2,491.4						1	2,491.4
Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг хангахгүй байна.	1	18,647.0						1	18,647.0
Дүн	3	21,138.4						3	21,138.4
Нийт дүн	4	30,982.4						4	30,982.4

7. Тайлан баталгаажуулсан тушаал



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 04 дугаар сарын 18

Дугаар А/10

Чингис хот

Аудитын тайлан
баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, МУЕА-ын “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хэнтий аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн санхүүгийн аудитын тайланг хавсралтаар баталсугай .
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Энх-Амгалан)-д үүрэг болгосугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 15 -ны өдрийн дотор тус тус аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Ц.Чогсомжав)-г зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Энх-Амгалан)-д даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Д.Оюунтуяа/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ж.ГАНБААТАР

232410020